

ЧИНГИС ХААНЫ ҮЕИЙН БӨӨГИЙН ШҮТЛЭГ

XIII зууны монголчуудын шашин шүтлэгийн
талаарх ойлголтыг товч авч үзэх нь.
Хожуу үеийн Монголын бөөгийн
шүтлэгийн үүрэг, зан үйлээс.

Ерөнхийд нь бидний товчоноор “бөөгийн шүтлэг” (“шаманизм”) гээд байгаа маань үнэн чанартаа, ялангуяа Умард Азид (Монголын нутгийг оролцуулан) бол шашин бус, харин түүнээс хавьгүй өргөн дэлгэр агуулгатай, байгаль дэлхий, түүний хүчнүүдэд “сүнс сүлд” оршдог хэмээн үздэг анимизмын хүрээний янз бүрийн төсөөллийг тусгасан цогц ухагдахуун болой. Товчдоо Йоханзеней тодорхойлсноор “бөөгийн шүтлэг нь шашин биш, харин [...] аль ч шашинд байж болох үзэгдэл, бөөгийн ид шидэнд үндэслэсэн шүтлэг”¹¹ билээ.

Бөө нь сүнсний болон хүний ертөнцийг өөр хооронд нь холбон зуучлагч бөгөөд эр, эм хүйстний аль нь ч байж болно. Бөө болох хүүхдийг ихэвчлэн шилжилтийн насанд нь тусгайлан сонгож аваад (бөө болох шинж ямар нэг онцгой өвчнөөр илрэх нь олонтаа тохиолдоно) бөөгийн эрдэмд сургасны дараа тэрбээр өөрийн отог омгийн өмнө хүлээсэн үүргийн дагуу сүнснүүдтэй холбоо тогтоодог. үүнийг ерөнхийдөө онгод орсон үедээ, сэтгэл санаагаараа бодит ертөнцөөс тасран нөгөө ертөнцөд аялах байдлаар гүйцэтгэдэг байна.²

Хэрэв бид Чингис хааны үеийн Монголын нийгмийг тусгайлан судалъя гэвэл шашин судлаач ч бай, түүхч ч бай тэрхүү үед

- 1 U. Johansen, Zur Geschichte des Schamanismus. Энэ нь: W. Heissig, H. J. Klimkeit, Synkretismus in den Religionen Zentralasiens (= Studies in Oriental Religions, Vol. 13), Wiesbaden 1987, 8-22-р нүүрт буй; энд: 8-9-р нүүр.
- 2 Йоханзеней мөн зохиолд буй тодорхойлолтыг үз. 8-9-р тал.

голбогдох эх сурвалж туйлын хомс байдаг нэг хүндрэлтэй асуудалтай хамгийн түрүүнд тулгарах болно. Дан ганц дотоодын төдийгүй (үүнд *Монголын Нууц Товчоо*³ хэмээх ганцхан эх сурвалж л бий), тухайн үеийн гэж болох аян замын тэмдэглэлүүд, мөн Персийн түүхчид Жувейни (1226-1283), Рашид ад-Дин (1247-1318) гэсхийгээд болчихдог гадаад эх сурвалжуудын хувьд ч байдал ялгаагүй ижил байна.⁴

Гэвч монгол бөөгийн үүрэг, гүйцэтгэдэг зан үйлийн тухайд амаар дамжин ирсэн онгодын дуудлага, сүлд дуу, дом шившлэг зэргээс асар ихийг мэдэх боломжтой ба өмнө нь ч бас иймэрхүү маягаар н уламжлагдаж байсан биз.⁵ Тэдгээрийн дөнгөж XX зуунд л сая нэг юм хагас хугас бичиж тэмдэглэж авчээ.

Энэхүү нийтлэлээ би дараах бүлгүүдэд ангилсан болно. Үүнд:

- 3 "Монголын Нууц Товчоон"-ы одоо байгаа орчуулгуудаас хамгийн эхний ба сүүлчийнхийг нь хамгийн сайн болсон гэж үздэг: Die Geheime Geschichte der Mongolen. Aus einer Niederschrift des Jahres 1240 von der Insel Kode'e im Kerulen-Fluss. Erstmalig übersetzt und erläutert von Erich Haenisch, Leipzig 1948; The Secret History of the Mongols. A Mongolian Epic Chronicle of the Thirteenth Century. Translated with a historical and philological commentary by Igor de Rachewiltz, 2 volumes., Leiden 2004.
- 4 Pars pro toto: Meng-ta Pei-lu und Hei-ta Shih-lüeh. Chinesische Gesandtenberichte über die frühen Mongolen 1221 und 1237, nach Vorarbeiten von Erich Haenisch (†) und Yao Ts'ung-wu (†), übersetzt und kommentiert von Peter Olbricht und Elisabeth Pinks. Eingeleitet von Werner Banck. (= Asiatische Forschungen, Bd. 56), Wiesbaden 1980; F. Risch, Johann de Plano Carpini, Geschichte der Mongolen und Reisebericht, 1245-1247, Leipzig 1930; F. Risch, Wilhelm v. Rubruk, Reise zu den Mongolen, 1253-1255, Leipzig 1934; Genghis Khan. The History of the World-Conqueror by Ata-Malik Juvaini, translated and edited by J.A. Boyle, with an introduction by David O. Morgan, Manchester 1997; Рашид ад-Диний зохиолыг орчуулсан, нийтлүүлсэн нь маш ховор: M. Weiers, Nahöstliche und europäische Quellen -ийг үзнэ үү. Энэ нь: M. Weiers (Hrsg.), Die Mongolen. Beiträge zu ihrer Geschichte und Kultur, Darmstadt, 1986, 18-28-р нүүрт бий, энд: 19-р нүүр.
- 5 Pars pro toto: B. Rintchen, Les matériaux pour l'étude du chamanisme mongol, I: Sources littéraires (= Asiatische Forschungen, Bd. 3), Wiesbaden 1959, II: Textes chamanistes Bouriates (= Asiatische Forschungen, Bd. 8), Wiesbaden 1961, III: Textes chamanistes Mongoles (= Asiatische Forschungen, Bd. 40), Wiesbaden 1975; W. Heissig, Mongolische volksreligiöse und folkloristische Texte (= Verzeichnis orientalischer Handschriften in Deutschland, Supplementbd. 6), Wiesbaden 1966.

- I. XII-XIII зууны үеийн улс төр, нийгмийн амьдралд монгол бөөгийн эзлэх байр суурь.
- II. Чингис хааны сүсэг бишрэл.
- III. Хожуу үеийн уламжлал, зан заншилд монгол бөөгийн гүйцэтгэх үүрэг, зан үйл.
- IV. Чингис хаан монголчуудын өвөг дээдсийн сүнс сүлдийг ивээн тэтгэгч болох нь.

I

Эртний Монголын нийгэм нь бүтцийнхээ хувьд ахмад настнаа хүндэтгэн дээдлэх, өвөг дээдсээ тахин шүтэх зарчимд тулгуурласан, эцгийн талын удам угсааг баримтлагч, отог омог дотроосоо гэрлэдэггүй ёстой байжээ. Тэнгэрт хальсан өвөг дээдсийн хүчирхэг онгод үр хойчоо ивээлдээ багтаан, аюул ослоос найдвартай хамгаалахын сацуу тэдэнд бас цээрлэл оноох нь ч бий. Дээр дурдсанчилан, сүнсний ертөнцийг хүний ертөнцтэй холбон зуучлагч нь бөө юм. Омгийн ч юмуу, овгийн ахлагчийн эзлэх байр суурь олон талаараа түүний шашин номын ид шидтэй шууд холбоотой байсан гэж үзэх үндэстэй бөгөөд энэ нь тухайн омгийн тэргүүн тусгай онгодын шидээр өвөг дээдсийнхээ сүнстэй, ереес сүнсний ертөнцтэй харьцаж чаддаг, мөн далдыг харах чадвартай байсан гэсэн үг юм. Товчхон хэлэхэд, тэр эрт цагт шашин номын ид шидийг үзүүлэгч нар нь хээр талын язгууртны давхаргын тэргүүлэгч биш юмаа гэхэд, ядаж л уг давхаргад харьяалагддаг хүмүүс байсан аж. ⁶Нэлээд тооны эх сурвалжаас үзэхэд мөн иймэрхүү шинж төлөв мэдэгддэг бөгөөд тэдгээрт гардаг “бэхи”⁷ хэмээх ухагдахууныг “ахлагч”, Владимирцовынхоор бол “*chef-tage*” гэсэн утгаар хэрэглэсэн байна. “Бэхи” гэдэг нь чухам юу гэсэн үг болохыг бид *Монголын Нууц Товчоон*-оос илүү нарийн мэдэж болно. Чингис хааны хэлсэн үгэн дотор:

“Монголын төр, ноён мөр “Бэхи” болохуй ёсон ажгуу. [...] Бэхи өргөөд, цагаан дээл өмсгөж, цагаан агт унуулж, суурь

6 J. P. Roux, *Le chaman genghiskhanide -r үзнэ үү. Энэ нь: Anthropos 54 (1959), 401-432-р нүүрт буй.*

7 G. Doerfer, *Türkische und mongolische Elemente im Neupersischen, Bd. I, No. 114, Wiesbaden 1963, 235-238-р нүүрт үзнэ үү (нийт 4 боть, 1963-1975).*

дээр суулгаж тахиж, бас он сар саатаж, тийн атугай”⁸ гэсэн нь буй.

Цаашилбал, *Монголын Нууц Товчоон*-д отог омог, бөөгийн ид шидийн хоорондын уялдаа холбоог Бодончарын хөвүүн Жэгүрэдэйгээр⁹ жишээ татан өгүүлжээ. Эцгийг нь үгүй болсны дараа түүнийг өөрийн овгийн хүмүүн бус гээд “зүхэл” хэмээх ёслолд оролцуулаагүй тухай энд гардаг. Эр нөхөр Есүгэйгээ нас нөгцсөний хойно тайчуудаас болж ээлүн эх мөн ийм хувь тавилантай учирч байсан билээ.¹⁰ Иймэрхүү маягаар отог омгоосоо зайлуулах нь түүнтэй мөн садан төрлийн холбоогоо тасалж буй хэрэг агаад энэ нь тухайн хүний хувь тавилан үндсэндээ шийдэгдлээ гэсэн үг юм.

Ямартай ч аль нэг отог омгийн юм уу, угсаатны бүлгийн өвөг дээдэс болон бөө нарын харилцан хамаарлыг нотлох сонирхолтой баримтуудыг, жишээ нь буриадын булгат, эхирит омгийнхон, эсвэл Ойрадын холбоонд харьяалагдаж асан өөлдүүд зэрэг монголчуудын гарал үүслийн тухай олон тооны домог түүхээс олж болно.¹¹ Түүнээс гадна П. С. Паллас бүр 1763 онд Ойрадын Чорос овгийн өвөг дээдэс болох “бөө хаан”-ы тухай дурдсан байдаг.¹²

Цаашилбал: бөөгийн шүтлэгийн гарал үүслийн тухай, цаг хугацаа нь тодорхойгүй боловч дотор нь гарч байгаа зүйлсээрээ бол XVII зууны хоёрдугаар хагаст л тэмдэглэж авсан болов уу¹³ гэлтэй

8 Монголын нууц товчоо, § 215-216.

9 Монголын нууц товчоо, § 43-44.

10 Монголын нууц товчоо, § 70-73. Мөн L. Ligeti, Le sacrifice aux ancêtres dans l'histoire secrète -ийг үзнэ үү. Энэ нь: Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae XXVIII, 1973, 145-161-р нүүрт буй.

11 W. Heissig, Shaman Myth and Clan-epic, энэ нь: W. Heissig, Schamanen und Geisterbeschwörer in der östlichen Mongolei (= Studies in Oriental Religions, vol. 24), Gesammelte Aufsätze, Wiesbaden 1992, 169-174 -р нүүрт буй.

12 W. Heissig, Schamanenlegenden und ihr historischer Hintergrund, энэ нь: Gedanke und Wirkung. Festschrift zum 90. Geburtstag von Nikolaus Poppe, hrsg. von W. Heissig, K. Sagaster (= Asiatische Forschungen, Bd. 108), Wiesbaden 1989, 152-174-р нүүрт буй, энд: 152-р нүүр.

13 W. Heissig, Die Religionen der Mongolei, энэ нь: G. Tucci, W. Heissig, Die Religionen Tibets und der Mongolei (= Religionen der Menschheit, Bd. 20), Stuttgart 1970, 308-р нүүрт буй; Хэсэгчилсэн орчуулга: W. Heissig, A Mongolian Source to the Lamaist Suppression of Shamanism in the 17th Century, энэ нь: W. Heissig, Schamanen und Geisterbeschwörer in der östlichen Mongolei, (=

Цахар нутгийн нэгэн домог мөн л өвөг дээдсээ тахин шүтэх, бөө нарын гүйцэтгэх үүргийн тухайд монголчууд эрт дээр үеэсээ ямаршуухан төсөөлөлтэй байсныг харуулах баримт мөн.

Амьдарна гэдгийг үнэхээрийн л үзүүлж байсан өвөг дээдсийнхээ сүнснээс өөр хэндээ ч хандах билээ дээ? Овгийн ахлагч ч бай, (эсвэл) бөө ч бай, тэдгээр сүнстэй холбоо тогтооход зайлшгүй шаардлагатай зуучлагч нарын байр суурь, гүйцэтгэх үүргийг тухайн нийгмийн эрэлт хэрэгцээтэй ямар нэгэн байдлаар холбон тайлбарлаж бас болно. Эрчимгүй мал аж ахуй, ан агнуурт тулгуурласан эдийн засагтай, иймээс ч байгаль, цаг агаарын ааш авирыг харж амь зуудаг нийгэмд амь нас, эрүүл мэнд, гал хөс, хоол унд, мал сүрэг, ан агнуур, үр хүүхэдтэй болох зэрэг уг нийгмийг авч явдаг гол зүйлсийг хадгалан хамгаалах хэрэгцээ шаардлага байх нь зүйн хэрэг.¹⁴

Монголчуудын бөөгийн шүтлэг, түүний тогтолцооны хувьд гэвэл XIII зууны үеийн түүхийн эх сурвалжууд, нэн тэргүүнд *Монголын Нууц Товчоо* болон Перс түүхчдийн тэмдэглэлд хөрст дэлхий (*Этүгэн*), хөх мөнх тэнгэр нь сүр сүлд, хүч чадлын манлай гэх үзэл монголчуудын ертөнцийг үзэх үзэлд нэвт шингэсэн тухай өгүүлсэн байдаг билээ. Тэнгэр, газар, од гариг, өвөг дээдсээ тахин шүтэх иймэрхүү үзэл бүр манай эриний эхэн зуунуудын үед Төв Азийн сүннү нар, мөн хожмын Төв Азийн түрэг угсаатнуудад (V-IX зуун) нэгэн адил байсан нь нотлогддог юм.¹⁵

Монгол болон Төв Азийн түрэгүүдийн хэлэнд "тэнгэр" гэдэг нь юуны өмнө цэнхэр огторгуйн хэлбэрээр бодитойгоор тогтнон байгаа материалаг тэнгэр хурмастыг хэлдэг ба түүнийг илч гэрлийг түгээгч эх, энэ ба дээд ертөнцийн бүхий л хүчний дээр

Studies in Oriental Religions, vol. 24), Gesammelte Aufsätze, Wiesbaden 1992, 61-135-р нүүрт буй, энд: 98-104-р нүүр.

- 14 W. Hellig, Religionen der Mongolei, энэ нь: G. Tucci, W. Heissig, Die Religionen Tibets und der Mongolei (= Religionen der Menschheit, Bd. 20), Stuttgart 1970, 308-р нүүрт буй.
- 15 S. I. Rudenko, Die Kultur der Hsiung-nu und die Hügelgräber von Noin Ula, übersetzt aus dem Russischen von H. Pollems (= Antiquitas 3, Bd. 7), Bonn 1969, 78-р тал; A. v. Gabain, Inhalt und magische Bedeutung alttürkischer Inschriften, энэ нь: Anthropos 48, 1953, 537-556-р талуудад буй.

орших бурханлиг зүйл хэмээн дээдэлдэг байна. ¹⁶ Иймээс “тэнгэр” хэмээгч нь амьтай юм бүхэнтэй холбоотой энэ ертөнцийн жам ёсыг хэлбэрэлтгүй сахиулагч агаад түүний гол шинж нь мөнх оршихуй болой. ¹⁷ Гэхдээ “тэнгэр”-ийг Христосын шашны маягаар бүхнийг бүтээгч Ертөнцийн эзэн хэмээн ойлгож хэрхэвч болохгүй. Христосын шашны Тэргүүн хамбын илгээсэн элч Плано Карпини жишээлбэл яг ийнхүү ухаарч:

“Тэд нүдэнд харагдах, үл харагдах бүхнийг бүтээгч нэг бурхан байдаг гэдэгт итгэдэг, мөн тэр бурхан нь энэ ертөнцийн бүхий л эд баялаг, гэсгээл шийтгэлийг хуваан оноодог хэмээн итгэх бөлгөө” ¹⁸ гэж бичиж байлаа.

II

Чингис хааны сүсэг бишрэлийн талаарх эх сурвалжуудаас бид юмар ойлголт авч болох вэ?

Энэ ертөнцөд оршин байгаа дээд тэнгэрийн сүнс онгод хүмүүний хувь тавиланд нөлөөлж чаддаг хэмээн итгэдэг монголчуудынхаа сүсэг бишрэлийг тэрбээр хуваалцдаг байсан нь лавтай. Гэхдээ “Мөнх тэнгэр” бүхий л ертөнцийн явдлыг болгоон зохицуулдаг бол сүнс онгодын хүч чадал зөвхөн тодорхой орон нутгаар хязгаарлагддаг гэж тэд үздэг байсан аж. Тиймийн учир Чингис өөрийг нь мэргидүүдийн довтолгооноос хамгаалан авч үлдсэн Бурхан Халдун уулын савдаг мэтийн ивээл хамгаалалд нэг талаар итгэдэг байжээ. *Монголын Нууц Товчоон*-д энэ тухай өгүүлэхдээ:

“Бурхан Халдунаа
Бөөсний төдий амиан
Булзуулдав, би.
[...]

¹⁶ Die Mongolengeschichte des Johannes von Plano Carpine, Einführung, Text, Übersetzung, Kommentar von Giessauf (= Schriftenreihe des Instituts für Geschichte, Bd. 6), Graz 1995, 133-р тал, зүүлт тайлбар 359-р тал.

¹⁷ U. Harva, Die religiösen Vorstellungen der altaischen Völker, Helsinki 1938, 145-р тал.

¹⁸ Die Mongolengeschichte des Johannes von Plano Carpine, Einführung, Text, Übersetzung, Kommentar von J. Giessauf (= Schriftenreihe des Instituts für Geschichte, Bd. 6), Graz 1995, 133-р тал.

Халдун Бурханаа
 Хараацайн төдий амиан
 Халхлуулав, би.
 Маш их айлгагдав, би.
 Бурхан Халдуныг
 Манагар (өглөө) бүр мялаасугай!
 өдөр бүр өчсүгэй!
 Ургийн ураг минь
 Ухтугай!"¹⁹ гэжээ.

Нөгөө талаар тэрбээр шийдвэрлэх тулалдаан болохын цагт Мөнх тэнгэртээ ханддаг байв. Харин Чингис тэнгэрийн тааллыг өргөл барьцын хүчээр хүртэх гэдэггүй, гагцхүү өөрийн үйл хэрэг цэгц шударгуу байхыг эрхэмлэдэг асныг онцлох нь зүйтэй. Иймэрхүү үед хаан: "Миний үйлдлийг зөв шударга хэмээн болгоож байгаа ахул над хүч, ивээлээ хайрламуу" гэж хэлэн Мөнх тэнгэрээ дууддаг байсан тухай Рашид ад-Дин мэдээлжээ.²⁰ Уулын орой дээр гаран бүсээ хүзүүндээн эрихлэж, дээд тэнгэртэй ярилцдаг энэхүү ёс заншлыг Хүлэгү (1218-1265) Багдадын Халифтай байлдахын өмнө, Бат (1207-1255) унгарчуудтай хийх тулааны өмнө тус тус үйлдэж байсан тухай дээрх сурвалжид мөн дурдсан байдаг.²¹

Сүнс онгодоор дүүрэн монголчуудын ид шидийн ертөнцөд үзмэрч нар бөөгөөсөө дутуугүй үүрэгтэй байсан агаад ер нь ч бөө, үзмэрч гэдэг нь тэртэй тэргүй ихэвчлэн нэг л хүн байдаг байв. Аливаа томоохон үйл явдлын өмнө үзмэрчид хонины далны яс шатаан, түүн дээр үүссэн ан цаваар мэргэлдэг байжээ.²² Чингис хааны хувьд ч энэ нь ихээхэн ач холбогдол бүхий зүйл байсан. Тухайлбал, тэрбээр өөрийн зөвлөхүүд дотроос Хятан Елюй Ахай болон Елюй Чүцай хоёрт онцгой итгэдэг байсан нь тэд хоёулаа мэргэ төлгийн урлагийг гарамгай эзэмшсэн байсантай нь багагүй холбоотой юм.²³ Түүнээс гадна Персийн түүхчид Чингис хаан

19 Монголын Нууц Товчоон, §103.

20 P. Ratchnevsky, Činggis-Khan. Sein Leben und Wirken (= Munchener Ostasiatische Studien 32), Wiesbaden 1983, 138-р тал

21 Ratchnevsky, мөн бүтээлд, 138-р тал, зүүлт тайлбар: 18-р нүүрт.

22 Cf., u.a., C. R. Bawden, On the Practice of Scapulimancy among the Mongols, энэ нь: C. R. Bawden, Confronting the Supernatural: Mongolian traditional ways and means. Collected Papers, Wiesbaden 1994, 111-142-р талд буй.

23 Ratchnevsky, мөн зохиолд, 139-140-р тал.

өөрөө ч мэргэлэхдээ муугүй, тэр бүү хэл ховсдлын байдалд ордог, тэр үедээ хэлж, тэмдэглэж авсан үгнүүдээ баримталдаг байсан тухай бичиж үлдээсэн байдаг.²⁴

"Мөнх тэнгэр"-ийг даруй хүнчилж, бие хүн Чингис хаан болгон хувиргасан нь дан ганц сүсэг бишрэлийн асуудал бус, яваандаа бас ч улс төрийн учир шалтгаантай болж, "дээд тэнгэрээс заяатай" ихэс дээдсийн үзэл суртлын эхийг тавьж байсан гэхэд болох байх. Эх сурвалжид байгаа дараах үг хэллэг тэнгэр язгуурын гэх энэхүү чиг хандлагын тулгуур үндэс болж байна. *Монголын Нууц Товчоон*-д Чингис хаан Мэргидүүдийг дарсны дараа:

"Тэнгэр газарт хүч нэмэгдэж ...
Эрхэт тэнгэрт нэрийдэж
Эх этүгэнээ хүргэж
Эрийн өшөөт Мэргид иргэнийг
өврийг ану хоосон болгов.
Элгийг ану эмтлэв, бид"²⁵ хэмээсэн тухай гардаг.

Цаашилбал:

"Мөнх тэнгэрт ивээгдэж, Хэрэйд иргэнийг доройтуулж, өндрийн оронд хүрэв зэ"²⁶

Гэжээ.

Эцэст нь тухайн цаг үеийн гэрч Вилхельм фон Рубруккийн 1255 онд бичиж үлдээснийг иш татъя (xxxvi, 6-12):

"Preceptum etemi Dei est. In celo non est nisi unus Deus eternus, super terram non sit nisi unus dominus Chingis Chan."²⁷

Үүнтэй уялдан, нэн ялангуяа эрт цагийн бөө заарин буюу отог омгийн ахлагчид л байдаг улс төрийн эрх мэдлийн хувьд гарсан үндсэн эргэлт бол "тэнгэр заяат" Тэв тэнгэр бөөг зайлуулсан явдал

²⁴ Ratchnevsky, мөн зохиолд, 140-р тал

²⁵ Монголын Нууц Товчоон, § 113.

²⁶ Монголын Нууц Товчоон, § 187

²⁷ K. Sagaster, Herrschaftsideologie und Friedensgedanken bei den Mongolen, энэ нь: Central Asiatic Journal 17(1973), 223-242-р нүүрт буй, энд: 242-р нүүр.

мөн. Тэрбээр Чингис хааны ордны нөлөө бүхий бөө, бүр түүний эцэг Есүхэйн албанд зүтгэж явсан үнэнч албат Мэнлигийн хүү, нэр алдар нь монгол овог аймгуудын хил хязгаараас халин гарсан нэгэн байлаа. Мөнх тэнгэр өөрт нь хандаж, "газар дэлхийг бүхэлд нь Тэмүжин, түүний хөвгүүдийн мэдэлд өгсү. Түүнийг Чингис хаанд өргөмжлөөд, улсыг зөв сэтгэлээр засч яв хэмээтүгэй"²⁸ гэж айлдсаныг уламжилсных нь төлөө ч гэх үү, Чингис хаан Тэв тэнгэрт хязгааргүй итгэдэг байв. Жинхэнэ нэр нь Хөхөчү хэмээх Тэв тэнгэр эрх мэдэлдээ эрдэж, Чингис хааны тогтоосон шинэ дэг жаягт дургүйцсэн цөөнгүй монголчуудад дулдуйдан:

"Мөнх тэнгэрийн зарлиг хан заарингууд өгүүлмү. Нэгэнтээ Тэмүжин улс барьтугай хэмээмү. Нэгэнтээ Хасарыг хэмээмү. Хасарыг эс нэндвээс, мэдээгүй буй зэ"²⁹

гэхчилэн өдөөж, хааны гэр бүлийнхний хооронд яс хаяхыг оролдох болжээ.

Нууц Товчоон-д өгүүлснээр, ах дүү нар биесээ хороохоос Өүлэн эх арайхийн сэргийлж амжсан авч албат иргэнээс Тэв тэнгэрт одон хурах нь улам нэмэгдсээр байсан тул эрх мэдлээ авч үлдье гэвэл энэ бөөг замаасаа зайлуулах нь гарцаагүй болов. Ингээд Тэв тэнгэрийг занганд оруулж, мөн л түүний явуулгаар отгон дүү Отчигинтой үүсээд байсан маргааныг уламжлал ёсоор хооронд нь барилдуулан цэглэхээр болсон байдаг. Гэтэл Отчигин гэрийнхээ үүдэнд гурван бөхийг зогсоогоод Тэв тэнгэрийг орж ирмэгц барьж авч нурууг нь хугалан хөнөөжээ. Тэв тэнгэрийн цогцсыг нэгэн гэрт оруулан тавьж өрхийг бүтээн, үүдийг дарж, хүнээр сахиулсан бөгөөтөл гутугаар шөнө нь алга болсон гэж *Монголын Нууц Товчоон*-д өгүүлдэг. Чингис хаан үүнийг тэнгэрийн тааллаар болов хэмээгээд:

"Тэв тэнгэр дүү нарт минь гар, хөл хүрсний тул, дүү нарын минь зуур оргүй жинхүхийн тул (оргүй худал хов зөөхийн тул) тэнгэрт эс таалагдаж, амь бие сэлтийг ину авч одов зэ"³⁰ гэжээ.

28 Ratchnevsky, мөн зохиолд, 88-р нүүр.

29 Монголын Нууц Товчоон, § 244.

30 Монголын Нууц Товчоон, § 246.

Ингэснээр Чингис хааны байгуулсан шинэдэг жаяг, түүнийг төлөөлж буй хүмүүс аль аль нь тэнгэрийн таалал болон хуульчлагдлаа. үүний илэрхийлэл болгож цаашдаа монголчуудын аливаа хууль зарлигийг "Мөнх тэнгэрийн хүчинд, их суу залийн ивээлд"³¹ хэмээн охэлж байхаар болсон байна.

Тэргүүн бөөгөөр Чингис хаан баарин нарын ургаас өөрт үнэнч нэгэн өвгөнийг томилж, түүнийг суурь дээр суулгаж тахиж, бас он сар саатаж, тийн атугай хэмээн зарлигласан гэж *Монголын Нууц Товчоон*-д гардаг тухай дээр нэгэнт дурдсан билээ. Чингис хаан ийнхүү хааны эрх мэдлийг бөөгийнхээс дээгүүрт гаргаж чаджээ.³²

Чингис хаан ч, түүний өв залгамжлагчид ч Христосын, Бүддийн, Бомбын, Лалын зэрэг олон шашны төлөөлөгчидтэй уулзаж учирч явсан. Гэвч Чингис хаан өөрийн удмын Их хаад, түүнчилэн Их Монгол Улсаас салбарлан гарсан улсуудын хаадыг бодвол өөрөө эдгээр шашны сургаал номлолыг төдийлөн сонирхдоггүй байв. Нэг талаас, бусад шашинд дайсагнан хандах нь бөөгийн шүтлэгт (үүнийг бид мөнхүү шүтлэгийн "шашны тал" гэж хэлэх байна) үндсээрээ харш зүйл, аливаа шашны "бурхан шүтээн"-ийг ердөө л нэмэгдэл маягийн, ондоо/ шинэ хамгаалагч хүч/ онгод сахиус, тэдгээрийг өөртөө татаж болно, харин тэдэнтэй тэмцэх шаардлага бол байхгүй гэж уг шүтлэгт үздэг, нөгөө талаас (үүнийг бөөгийн шүтлэгийн "төрийн буюу улс төрийн тал" гэж болох юм) сүсэг бишрэлтэй холбоотой зөрчил тэмцэл нь эзэнт улсын дотоодын энх амгаланд ямар аюул учруулж болохыг Чингис хаан мэддэг байсан. Ер нь ч сүсэг бишрэлийн эрх чөлөө олгох нь холбоотон, үнэнч зүтгэлтнүүдийг өөрийн талд татах чухал арга хэрэгсэл юм. Тухайлбал, баруун этгээдэд хийсэн аян дайны үеэр Самарканд хотын томоохон санваартнууд, тэдний дагалдагсдыг хамгаалалдаа авах баталгаа гаргаж өгч байсан нь үүний нэг жишээ гэж ойлгох хэрэгтэй.³³ Тийм ч учраас монголчууд шашин шүтлэгт хүлээцтэй хандах талаараа онцгой байсан талаар монголчуудын үйлдлийн бүхий л гэрчүүд санал нэгддэг; Монголын хууль цаазын хүрээнд харийн шашныхныг албан татвараас чөлөөлөх болон тэдний амь

31 M. Weiers, *Geschichte der Mongolen*, Stuttgart 2004, 106-p тал.

32 Ratchnevsky, мөн зохиолд, 91-p талд.

33 Ratchnevsky, мөн зохиолд, 118-p талд.

насыг хамгаалсан бичиг захидал олгож байсан нь үүний бас нэг нотолгоо мөн.³⁴

Францын Эзэн хаан IX Людвигийн даалгавраар 1253-1255 онуудад Хархорум дахь Их Эзэн Хааны ордонд очсон Францискан урсгалын гэлэн Вилхельм фон Рубрукийн талаар өмнө нэгэнт дурдсан. Тэрбээр Христос, Бүддийн, Бомбын болон Лалын шашны төлөөлөгчдийн дунд өрнөсөн мэтгэлцээнийг дүгнэсэн хариу болгож Мөнх хааны хэлсэн доорх алдарт үгнүүдийг өнөөгийн бидэнд уламжлан үлдээсэн билээ:

“Монголчууд бид [...] цор ганц бурхан байдаг, бидний үхэх, амьдрахыг энэ бурхан л мэддэг гэдэгт итгэдэг [...] Бурхан хүний гарт олон хуруу суулгаж өгсөн шигээ хүмүүст ч бас амьдралын олон янзын зам мөр заяажээ [...] Бурхан та бүхэнд бичиг ном хайрласан, та бүхэн түүнийг нь дагасангүй; бидэнд болохоор үзмэрчдийг илгээсэн, бид тэдний хэлснийг дагаж амар жимэр амьдарцгааж байна”³⁵

III

Нийтлэлийнхээ дараагийн хэсэгт би хожуу үеийн уламжлалд Монголын бөөгийн шүтлэгийн гүйцэтгэсэн үүрэг, зан үйлийн талаар авч үзэхийг зорив. Энэ асуултад хариу өгөх дом шившлэг, сүнс онгодын дуудлага, зарлиглал зэрэг эх сурвалжууд анхандаа бараг бүгдээрээ амаар дамжин өвлөгдөж ирсэн, нэлээдийг нь дөнгөж XX зуунд л бичиж тэмдэглэж авсан зүйлс байдаг тухай нийтлэлийн эхэнд нэгэнтээ өгүүлсэн билээ. Энэ удаад миний бие бөө нарын үүрэг, тэдний зан үйлээ гүйцэлдүүлж асан байдал Чингис хааны үед ямар байсан, яг л тэр хэвээр нь арай өргөн хүрээнд, арай амьд сонирхолтойгоор харуулах зарим нэг оролдлого хийхээр зориглосон болно.

34 Ratchnevsky, мөн зохиолд, 173-174-р талд. E. Haenisch, *Steuergerechtesame derchinesischen Klöster unter der Mongolenherrschaft: Eine kulturgeschichtliche Untersuchung mit Beigabe dreier noch unveröffentlicher Phagpa-Inschriften*, Leipzig 1940.

35 Ишлэлийг: Chr. Dawson (Ed.), *The Mongol Mission*, New York 1955, 195-р тал; Rubruck, Kap. XXXIV

Хорвоогийн жам ёсны тухай монголчуудынх шиг ийм сэтгэлгээнд уул уснаас авхуулаад газар шороо хүртэл бараг юм бүхэн амьтай, өөрөөр хэлбэл сүнс савдагтай байдаг хэмээн үздэг байна. Иймээс бөөгийн шүтлэгийн үндсэн үүрэг нь бүхий л аюул занал, өвчин эмгэг, гамшиг зовлонгийн шалтгаан болдог гэх муу зүгийн төрөл бүрийн сүнсний хорлолоос хүн, түүний эд агуурсыг хамгаалахад оршино. В. Хайссигийн баттай үзэж буйгаар³⁶ бөө хүн ийм тусламж үзүүлэхдээ өөрийн хийсэн энэ үйлдэл хойд насанд нь буюу нөгөө ертөнцөд очсон хойно нь хэрэг болж болзошгүй гэсэндээ биш, ердөө л энэ яваа амьдралд нь тус дэм болох гэсэнтэй нь холбоотой гэдгийг онцлох учиртай юм байна. үүнээс үзвэл бөөгийн шүтлэг нь тодорхой зорилго бүхий, зөвхөн өнгөрсөн ба одоод чиглэсэн, мэргэ төлгийг эс тооцвол ирээдүйн тухай төсөөллөөс ангид шашин юм.³⁷

Тэгэхээр Монголын бөөгийн шүтлэгийн зорилго яг нарийндаа юу байсан бэ гэдгийг хэдийгээр шинээр тохоон томилогдож буй Буриадын бөөгийн тангаргаар (хэдийгээр тэр нь дангаараа гүйцэд харуулж харуулж чадахгүй ч гэсэн) жишээлэн авч үзье. Лав л 1836 онд хэрэглэсээр асан уг тангарагт:

“Би бээр газар газрын ард зон руу очиж, муу зүгийн ад зэтгэрийг тэдний биеэс зайлуулан, хүмүүнийг өвчин зовлонгоос ангижрахад нь тусалмой”³⁸ гэсэн байдаг.

Тэрчлэн чухам юу юуны учир онгод сахиус дууддагийг судалсан урьдчилсан судалгаанаас үзэхэд энэ нь мөн л дээр цухас дурдсан зүйлст, өөрөөр хэлбэл хоол хүнс, олз омог, мал хуй, урт нас, үр удам, энх тунх амьдралыг хүсэх, бас өвдөж шаналах, өвчин тахалд өртөх, гай зовлон, дайсан этгээдээс хамгаалахад чиглэдэг гэсэн дүн гарчээ. Хайссигийн үзэж байгаагаар³⁹, бие махбодийн хийгээд ахуйн хэрэгцээг хангах, түүнийг хамгаалах явдал бөөгийн

36 W. Heissig, Die Religionen der Mongolei, энэ нь: G. Tucci, W. Heissig, Die Religionen Tibets und der Mongolei (= Religionen der Menschheit, Bd. 20), Stuttgart 1970, 310-р талд буй.

37 Heissig, мөн зохиол, 311-р тал.

38 Heissig, мөн зохиол, 310-р тал, N. Poppe, Aufzeichnungen bei den Chori-Burjaten, Leningrad 1935 –аас ишлэн авсан.

39 Heissig, мөн зохиол, 311-р тал.

нэн тэргүүний зорилго байсныг илтгэх хамгийн гол нотолгоо бол Төвдөөс Бүддийн шашныг нь авсны дараа ч Шарын шашны бурхдыг тодорхой хэмжээгээр өргөтгөж, мөн л дээрх зүйлсийг ивээлд нь багтаах, хадгалан үлдээх зорилгоор тэдгээр сахиус, бурхдыг урин залж дууддаг зан үйл аж.

Тэгвэл бөө хүн бусдын өвчин эмгэгийг илааршуулах, гай зовлонгоос хамгаалахын тулд үйлдэж асан тэдгээр зан үйл хэрхэн явагддаг байв? Монголчууд үүнд “бөөлөх”, “үзмэрлэх” гэсэн ухагдахуунуудыг хэрэглэдэг. Эхнийх нь нэр үгнээс, өөрөөр хэлбэл “бөө” (германаар “шамане”) хэмээх үгнээс үүссэн үйл үг бөгөөд үүнийг бид германаар “шаманизийрень” гэж орчуулж болох юм. Монголын уламжлалаар үүнийг дараах байдлаар тодорхойлдог. үүнд: “Сахиус/ онгодыг урин залж бөөгийн биед оршоогоод, тэдэнд тодорхой үүрэг даалгавар өгч, түүнээ биелүүлүүлнэ.” Тэгвэл “үзмэрлэх” гэдэг нь үүсмэл үйл үг бөгөөд „үзэх, харах” гэсэн энгийн утга бүхий “үзэ-” гэдэг үгийн үндсээс гаралтай аж. үүнээс үүсэлтэй „үзмэрлэ-” гэдэг нь “үзэгдэхүйц, ил болгох” гэсэн утгатай, гол төлөв мэргэ төлгийн урлагтай холбоотойгоор хэрэглэгддэг үг юм. Бөөлөх гэдэгт товчхондоо дараах үйлдлүүд орно:⁴⁰ 1) хүн өвчлөхөд биеэс нь өвчин эмгэг, үхлийн аюулыг хөөн зайлуулахын төлөөнөө бөөгийн тамлага дуудлага, өргөл барьцын хүчээр тодорхой нэг сахиус онгодод нөлөөлөх. 2) гай түйтгэр, өвчин зовлонг үүсгэгч ад зэтгэрийг хөөн тонилгох. Энэхүү зан үйлийн үндэс нь бөө хүн муу зүгийн ад зэтгэрийн эсрэг тэмцэлд өөрийн сахиус онгодыг сөргүүлэн тавьж болно гэж үздэгт оршино. Муу юмыг тонилгохдоо түүнийг орлуулсан дүрс зургийг (монголоор: золиг) шатаах, эс бөгөөс ямар нэг мал, амьтанд шингээн түүнээ нядлах замаар гүйцэтгэдэг байна.⁴¹ 3) Амьтай, амьгүй өмч хөрөнгөнд гай түйтгэр учирваас түүнийг хөөн тонилгох. 4) Тарни, шившлэг үйлдэх, хараал хийх. 5) Мэргэ төлгө.⁴²

40 Heissig, мөн зохиолд, 311-312-р тал; түүнчилэч: мөн зохиогч, Schamanen und Geisterbeschwörer im Küriy-e Banner, энэ нь: W. Heissig, Gesammelte Aufsätze, Wiesbaden 1992, 1-50-р нүүрт буй.

41 W. Heissig, Banishing Illnesses into Effigies in Mongolia, энэ нь: W. Heissig, Gesammelte Aufsätze, 1992, 157-167-р талд буй.

42 C. R. Bawden, Astrologie und Divination bei den Mongolen – die schriftlichen Quellen, энэ нь: C. R. Bawden, Collected Papers, 1994, 20-40-р талд буй.

Төгсгөлд нь бөөгийн онгод сахиус, түүний хувцас хэрэглэл, бөө болох ёсны талаар товч өгүүлье.

Онгод буюу сахиус гэж бүр Чингис хааны үед байсан төдийгүй гэдгээр нь ямар хэлбэрээр илрэн гарч байсан тухай мэдээ баримтыг бидэнд үлдээсэн хүн бол өөр хэн ч биш, мөнөөх Христос шашны Тэргүүн хамбын элч Плано Карпини бөлгөө. Энэ тухай гэрбээр бичихдээ:

"... тэд эсгийгээр хийсэн хүний дүрсийг шүтээн болгож гэрийнхээ хаалганы хоёр талд хадсан байдаг. Энэхүү шүтээний доор малын дэлэнг дуурайлган хийсэн эсгий дүрсүүд байрлуулах ба эднийгээ мал сүргийг харж хандаж явдаг хэмээн үзэж сүү болон бага насны малаар тахил өргөдөг. Мөн торгоор өөр бусад шүтээнүүдийг хийж тахил ёсон бий"⁴³ гэжээ.

Энэхүү онгод хэмээгч нь хамгаалагч сахиус, сүнсүүдийг дүрсээр илэрхийлсэн хэрэг агаад тэдгээр нь өвөг дээдсийн сүнс, дээд тэнгэрийн юмс, Эзэн хаан, тэдгээрийн шинж чанарын төлөөлөл болох буюу эсвэл амьтны хэлбэрээр мал сүргийг хамгаалах үүрэг гүйцэтгэдэг байна. Тэгээд ч бөө бүхэн, мөн нутаг орон бүр өөр өөрийн онгод сахиустай байдаг учраас сайн, муу хүчин биеллээ олохдоо газар бүр харилцан адилгүй байдаг. Онгод ямар үүрэгтэй болох талаар буриадууд: "Олон жилийн өмнө тэнгэрт хальсан бөө, удгануудын сүнс уул нурууд, гол мөрөн, нуур цөөрөм, горхи шанд, ой хөвчийг эзэгнэгч онгод болон хувирч аливаа амьтанд ач ивээлээ хайрлах нь ч бий, хор хөнөөл учруулах нь ч бий"⁴⁴ хэмээн ярьдаг нь өдгөө уламжлагдан үлджээ. Ийнхүү өөрсдөд нь таатай хандан ивээгч онгодуудын тусламжтайгаар бөө нар янз бүрийн чөтгөр шуламнаас гадна мөн муу хүмүүсийн сүнс зэрэг хор хөнөөл учруулагч хүчний эсрэг тэмцдэг аж. Бөөгийн шүтлэгт үндсэндээ нөгөө ертөнц гэдэг ойлголт байдаггүй бөгөөд нас барсан өвөг дээдсийн сүнс энэ ертөнцөд оршоор байдаг, тэдгээр нь эерэг ч бай, сөрөг ч бай өөр бусад сүнсийг эзэмдэх чадвартай хэмээн үзсээр иржээ. Жинхэнэ ураг төрлийн хувьд ч, домог түүхээрээ ч өвөг дээдэс нь хэдийчинээ олон үе дараалан онгод болж, бусад

43 Giessauf, Mongolengeschichte, 133-р тал

44 Heissig, Religionen, 313-314-р тал.

олон сүнс, онгодыг эрхшээлдээ оруулан өөрийн болгосныг нотолж чадна, тэр бөө төдийчинээ хүчтэй байна.⁴⁵

Бөөгийн үүргээ гүйцэтгэхэд, тухайлбал өөр бусад ертөнцөд очихын тулд маш олон тооны тусгай хувцас хэрэглэл зайлшгүй шаардлагатай байдаг. Үүнд, нэн тэргүүнд эрэгтэй, эмэгтэй гэсэн хүйсийн ялгаагүй, бүгд адил хэлбэртэй байдаг бөөгийн өмсгөлийг дурдах нь зүйтэй. Зөвхөн монголчуудынх ч бус, мөн түнгүсүүд, Сибирийн үндэстэн ястнуудын бөөгийн өмсгөлд зарим нэг нарийвчилсан хувилбарыг эс тооцвол ижил зүйл олон буй. Эдгээр нь бөөгийн ёслолын хувцас явж явж Умарт Азийн үлэмж хэсгийг хамаарсан, маш эртний баялаг уламжлалтай болохыг гэрчилдэг юм.⁴⁶

Монголын бараг бүх бөө нарын өмсгөл ар нуруун дээр нь хаагддаг урт нөмрөг маягийн зүйл байдаг. Түүн дээр нь төмөр унжлага, хонх сэлтийг оёж тогтоосон, хоёр ханцуй, энгэрт нь шувууны далавчийг бэлэгдсэн илгэн юмуу даавуун цацаг хадсан байна. Мөн олон өнгийн туузаар эрээлж хийсэн хормогчийг бөөгийн өмсгөлд оруулсан байх нь цөөнгүй тааралдана. Бөөгийн нөмрөгийг монголчууд бүхэлд нь "хуяг" гэж нэрлэдэг ба тэр нь онгодын дүрсүүдийн нэгэн адил дараа үедээ өвлөгддөг.

Цаашилбал, бөөгийн толь онцгой гүн утга агуулна. Цээжиндээ, эсвэл нуруундаа зүүдэг, хорин сантиметр орчим голчтой дугариг толины үүрэг нь муу зүгийн ад зэтгэрийг айлган үргээх юм. "Ээж-эгчийн өргөлд ирсэн, луун хээт улаахан толь минь, өлгийтэй нялхсад шүглэсэн чөтгөр шулмыг дарагч минь ээ" гэж бөөгийн нэгэн тамлага дуудлагад гардаг билээ.⁴⁷ Толь нь бас муу зүгийн хүчний тавьсан нүдэнд үл үзэгдэх сумыг хааж, бөөг өөрийг нь хамгаалах чадалтай. Түүнчлэн гадна хийгээд дотор байгаа бүх зүйлийн тусгал, бүр далдын далд байгаа бодол санааг ч илчилдэг гэнэм. Тиймийн учир бөө хүн толиныхоо хүчээр бүхнийг мэдэгчийн байр сууринд очдог байна.⁴⁸

45 Heissig, мөн зохиол, 316-р тал.

46 Heissig, мөн зохиол, 316-324-р тал.

47 Heissig, мөн зохиол, 319-р тал.

48 Heissig, мөн зохиол, 320-р тал

Бөөгийн толгойн чимэглэлийн хувьд бидний мэдэх зүйл гэвэл, Умарт Азид түгээмэл тохиолддог төмөр эвэртэй дуулган малгайнаас гадна амьтны арьс, эсвэл ихэвчлэн улаан өнгийн алчуураар хийсэн титэм маягийн өмсгөлийг хэлж болно. Харин төмөр эвэр нь ямар нэг хамгаалагч амьтныг бэлгэддэг гэвэл Хайссигийн үзэж буйгаар⁴⁹, ямар ч байсан зүүн монголчуудын хувьд энэ утгаа алдаад байгаа аж.

Эцэст нь бөөгийн сүр хүчнийг илтгэх бэлгэдлийн чанартай хамгийн чухал эд зүйлийн тоонд дамар, саваа хоёр нь орно. Остякууд, ениссейчүүд, жукагирууд, түнгүүсүүд болон Амар мөрний дагуух үндэстэн ястнуудын хэрэглэдэг дугариг хэлбэртэй дамар гэж байдаг бол монголчууд хийгээд Мүгдэн хавийн манж нарын тусгай бариул бүхий дотроо шаржигнууртай дамар бас бий. Энд дашрамд нэгэн сонин уламжлалын талаар өгүүлэхэд, Бээжин хотын хүүхдүүд бүр XX зууны эхэнд хүртэл ийм шажигнадаг дамран тоглоомоор тоглодог байв. Буга урамдах мэт сонсогдох дамрын чимээ нь ад зэтгэрийг айлган үргээдэг ажээ.⁵⁰

Саваа нь ч гэсэн дотроо хоёр янз.⁵¹ Нэг нь дээд үзүүртээ морины толгойн дүрстэй, доод үзүүрт морины туурай сийлсэн байдаг. Дунд хэсэг нь заримдаа эмээлийн дүрстэй, тэр бүү хэл дуурайлган хийсэн жижигхэн дөрөө хүртэл байх нь тааралдана. Энэхүү саваа нь бөөг хорон муу санаа өвөрлөгч ад зэтгэртэй тулалдахаар одоход унаа нь болж, онгодоо орсон үед шидэт хүлгээ хөлөглөн (шидэт хүлгээрээ нисэн) аялах боломжийг түүнд олгох учиртай юм. Савааг үүнээс гадна могойн арьсаар бүрж хийсэн нь ч бий. Ийм савааны нэг үзүүрт олон өнгийн даавуу уясан байдаг нь түүгээр дамрыг цохихын цагт могойн хэл бултганах болон могойн биеийн хөдөлгөөнийг дуурайлгахын тулд гэнэ (энэ нь хамгаалагч амьтны үүргийг илэрхийлж байгаа болов уу?). Энэ мэтээр хоорондоо өчнөөн ялгаатай байлаа ч дараах үндсэн үүргүүд нь

49 W. Heissig, Die Religionen der Mongolei, энэ нь: G. Tucci, W. Heissig, Die Religionen Tibets und der Mongolei (= Religionen der Menschheit, Bd. 20), Stuttgart 1970, 320-р талд буй.

50 D. Bodde, Annual Customs and Festivals in Peking, Peiping 1936, 78-р тал.

51 W. Heissig, Die Religionen der Mongolei, энэ нь: G. Tucci, W. Heissig, Die Religionen Tibets und der Mongolei (= Religionen der Menschheit, Bd. 20), Stuttgart 1970, S. 320-324-р талд буй.

хэвээр байдаг. үүнд: өөр ертөнц рүү хийх шидэт аялал болон алив муу муухайгийн үр үндсийг тавигч, өөрөөр хэлбэл чөтгөр шулмыг айлган тонилгох буюу даран сөнөөх үйлдэл. Бөөлөхдөө гаргадаг их дуу чимээ нь дээрхэд хамгийн их нөлөөлдөг хүчин зүйлийн гадаад илэрхийлэл мөн.

Бөөгийн шүтлэгийн гол цөм үзэгдэл нь эцсийн бүлэгт (*last not least*) нөгөө ертөнц рүү хийх аялал болох нь мэдээж⁵². үүнийг үйлдэхдээ бөө нь архи, тамхи, мансууруулагч ургамал зэргийн нөлөөн дор, дамраа тачигнуулан огцом хурдан эргэлдэх хөдөлгөөн хийх зэргээр ер бусын байдалд орох буюу онгодоо оруулдаг. Ийм үедээ тэрбээр өөрт туслагч сүнс, онгодуудтайгаа холбоо тогтооно. Бөө тэднийг өөр дээрээ дуудан ирүүлсний дараа түүний өөрийнх нь сүнс биенээсээ гарч, бусад сүнс рүү аялан оддог байна.

Үүнээс гадна буриадуудын дунд онгодоо оруулах өөр нэг хэлбэрийн арга байна. Туслагч буюу хамгаалагч сахиус онгод бөөгийн биед нэвтрэн ороход бөө яг л түүнтэй адилхан ааш аяг гаргах агаад хэргээ гүйцээмэгц тэрхүү сүнс онгодыг биенээсээ буцаан гаргана.⁵³

Бөөлөх ёслолын бас нэг хэсэг нь дуулах бөгөөд дуугаараа бөө нь онгодоо дуудан ирүүлнэ. Ирсэн хойно нь тэрбээр сүнс онгодыг магтан дуулж, өөрийн хэрэг зоригоо айлтгаад, хариуд нь муу муухайн үр үндсийг мэдэж авч, түүнийг даран устгадаг бөлгөө. Төгсгөлийн дуугаараа онгодод талархснаа хэлээд, эцэст нь түүнийг чөлөөлөн явуулдаг аж.⁵⁴

Төгсгөлд нь бөөгийн авьяас илрэх болон бөө болох ёслолын талаар хэдэн үг хэлье.⁵⁵

52 Hierzu die Beobachtungen von Heissig, Schamanen und Geisterbeschwörer, 12-16-р тал.

53 E. und M. Taube, Schamanen und Rhapsoden. Die geistige Kultur der alten Mongolei. Tusch: Wien 1983,

104-р тал.

54 Бөөгийн дуунуудыг түүвэрлэн авсан номын тухайд: Heissig, Schamanen und Geisterbeschwörer –ыг үзнэ үү, 16-31-р тал.

55 G. Sanjeev, Weltanschauung und Schamanismus der Alaren-Burjaten –ыг үзнэ III, энэ нь: Anthropos 22, 1927, 576-613, 933-955-р тал; 1928: 538-560, 967-986-р

Угтаа бөөлөх нь ураг төрлийн хүрээнд дамжин өвлөгддөг, өөрөөр хэлбэл эцгийн, эсвэл эхийн талд бөөгийн удамтай хүн л бөө болдог гэсэн үг юм. Бөөгийн авъяас гэнэт илэрч болно, харин ийнхүү илрэх нь гарцаагүй зүйл бөгөөд түүнээс зайлсхийх арга байдаггүй! Авъяасын шинж нь өвөг дээдсийн сүнсээр дамжин ямар нэг юманд шаналан сэтгэлээр унах, хар дарж зүүдлэх, хий юм харах, уран цэцэн ярих, бие нь чичирч татганах, хүндээр өвчлөн үе үе ухаан алдаж унах, турах зэргээр мэдэгдэнэ. өвчний шинж илэрсэн ийм үед өвөг дээдсийн сүнс өөрсдийн үйл хэрэг, авъяасыг үргэлжүүлэхийг шаардаж байна хэмээн итгэдэг байв. Тэдний ойлголтоор энэ нь, тэдгээр сүнс шинээр бөө болж буй хүнийг тэнгэрт аваачин түүнд юуг илааршуулах чадвартай болох, ямар онгод түүнийг түшиж тулж явдаг, ямар сүнсний эсрэг тэмцэх ёстойг нь зааж өгч буй хэрэг ажээ.

Бидний газар дээр нь хийсэн судалгааны дүнд ялангуяа Буриадын шинээр тодорч буй бөө маш их зовж шаналж байж “өөрийн отог омгийнхныхоо төлөө ер бусын байдлаар биеэ золиосолдог” тухай олж мэдсэн билээ.⁵⁶ “Цаг нь ирсэн”-ийг бэлэгдэн бие хааг нь хэсэглэн тасчиж, үе мөчөөр нь жиргэн салгаж, махыг нь чанаж болгоод, цусыг нь цацан үсчүүлнэ. Бүхнийг өөрийн нүдээр ажиглан харах ёстой учраас урьд нь цавчаад авчихсан толгойг гэрийн дотор өндөрлөсөн суурин дээр байрлуулна. Зүүдэндээ үзэх энэхүү аймшигт ёслолын төгсгөлийн шатанд сүнсүүд ирж бөөг ахин сэргээхдээ бүх ясыг ширхэг ширхгээр нь буцаан эвлүүлж, шинэ махаар бүрж өгнө. Энэ хугацаанд 3-6 орчим хоногийн турш шинэ бөө маань амь нь гарсан мэт бөх нойрсож байдаг. Чингэхдээ түүнийг нэг бол өөрийнх нь суудаг гэрийн баруун талд хөшгөөр тусгаарлан байрлуулж, эс бөгөөс хүн амьтангүй эзгүй газар барьсан майханд унтуулдаг байна. Ингэж байхдаа тэрбээр манаатай байх агаад хэн ч түүний биед хүрэх ёсгүй, бас ямар ч хоол, унд үл хэрэглэнэ. Энэ үеэр түүний ураг төрлийнхөн хүрэлцэн

талд буй. Энд: S. 976-984-р тал; H. Findeisen/ H. Gehrts, Die Schamanen. Jagdhelfer und Ratgeber, Seelenfahrer, Kunder und Heiler. Diederichs Gelbe Reihe Nr. 47, 1983, нэн ялангуяа 46-74-р тал; M. Eliade, Shamanism. Archaic Techniques and Ecstasy, Princeton University Press, 1970, ялангуяа 18-22, 43-45, 115-122-р тал.

56 Findeisen, мөн зохиол, 62-65-р тал.

ирж, "манай бөө эргэн амилаад бидэндээ туслах болно!" хэмээн дуулалдах ажгуу.

Бөө нар ийнхүү өөрийгөө гаргуунд нь гаргаснаар өөрийн биеэр туулж өнгөрүүлсэн ийм аймшигт зовлон гамшгаас гэр орныхон, отог омгийнхноо хол хөндий байлгах боломжийг түүнд олгодог байнам.

Тухайн сорилтыг даван туулж байгаа шинэ бөө нар насаар залуухан, дөнгөж 12-14 насны хооронд л байдаг. Эргэн сэргээд энх тунх болсныхоо дараа тэрбээр аль нэгэн эцэг бөөг даган отог омгийн удам судар, уламжлалт ёс заншил, бөө мөргөлийн домог түүх, бөөгийн үг хэллэгт суралцдаг аж.

IV

Бид Чингис хааны тухай яриа руугаа эргэн орж, энэхүү түүхийн тойргоо эцэслэе. Түүний ач хүү, Юань гүрний анхны Эзэн хаан Хубилайг төр барьж байх үед (1260-1294) Чингис хаан өөрөө бөө шүтлэгтнүүдийн ёсоор өвөг дээдсийн онгод хэмээн тахигдсан бололтой байна. өрөөл бусдад хүчирхэг өмөг түшиг болох өвөг дээдсийн сүнсний үүргийг өөртөө авснаар Чингис хаан нь зөвхөн отог омгийнхоо сайн сайхны төлөө үйлчлээд зогсохгүй нийт зон олны Эзэн хааны хувьд аугаа их рид чадлыг олж, тэнгэрт хальсан хойноо ч даяар монголчуудын аз хийморийг түшиж явдаг бөөгийн шүтлэгийн онгон шүтээн болон хувирсан ажээ.⁵⁷

Үүний илэрхийлэл болж, халх нутгийн нэгэн бөөгийн дуудлагад "Боржигад овгийн эрхэмсэг сүлд болсон, дээдийн дээд аз заяатан, азын тэнгэрийг ивээн тэтгэгч ариун шүтээн Эзэн хаан мину зэ!"⁵⁸ гэж гардаг билээ л.

57 Heissig, Religionen, 364-370-р тал К. Sagaster, Die Weiße Geschichte. Eine mongolische Quelle zur Lehre von den Beiden Ordnungen. Religion und Staat in Tibet und der Mongolei. (= Asiatische Forschungen Bd. 41). Harrassowitz: Wiesbaden 1976, 204-р тал болон бусад.

58 Rintchen, В, Chamanisme mongol I, 1959, 94-р тал.